



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙГ ШИНЭЧЛЭН НАЙРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ХОЛБОГДОХ ЗӨВЛӨМЖИЙН ХУРААНГУЙ

Европын Холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын болон хуулийн төслийг шинэчлэн боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Тус зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг шинэчлэн найруулах, дагах хуулиудын төсөл боловсруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлсоны үндсэн дээр холбогдох бодлогын зөвлөмжийг боловсруулсан юм.

ҮНДЭСЛЭЛ БА ШААРДЛАГА

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай 2001 оны хууль, 2011 оны шинэчилсэн найруулгын аль аль нь манай улс нэгдэн орсон ОУХБ-ын “Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай” 122 дугаар конвенцийн дагуу макро түвшний хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчин бүрдүүлэх асуудлыг хөндөөгүй. Өөрөөр хэлбэл үндэсний хөгжлийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийн баримжаатай болгох асуудал үндсэндээ орхигдсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид эдийн засгийн харилцааг зохицуулж байгаа голлох хуулиуд хамрагдахгүй байна.
- 2011 оноос эхлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлэх болсноос хойш хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх асуудалд бага анхаарч ирсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нийт зардалд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн эзлэх хувь 2018-2023 онд 0.9-2.4 хувийн хооронд хэлбэлзэж байв.
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын “Хөдөлмөр эрхлэлтийн албаны тухай” 88 дугаар конвенци, “Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай” 181 дүгээр конвенцид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль нийцээгүй байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нэг жилийн циклтэй, улирлаас хамааралтай, үр дүнгээ “Зарцуулсан хөрөнгө”, “Хамрагдсан хүний тоо” гэсэн 2 үндсэн үзүүлэлтээр хэмждэг, төрийн захиргааны ажилтанд сууринласан үйлчилгээ (State administration officer centered employment service) үзүүлдэг гэсэн голлох шинжээр тодорхойлогдож байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого үндсэндээ гадаад ажилтан ажиллуулсан ажил олгогчийн төлдөг төлбөрөөс хамааралтай болсон. Гэтэл энэ сангийн өнөөгийн орлого хангалттай биш болох нь, жишигээлбэл Коронавируст халдвартын цар тахлын үед нотлогдсон. Нөгөө талаас хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй болон идэвхтэй бодлогын уялдаа алдагдсанаар ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлэх үйл ажиллагааг үндсэндээ ажилгүйдлийн тэтгэмж олгох хүрээнд хязгаарласан байна. Сүүлийн 6 жилийн байдлаар эдгээр сангас хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй ба идэвхтэй бодлогын арга хэмжээнд зарцуулсан зарлагын ДНБ-д эзлэх хувь 0.26-0.44%-ийн хооронд хэлбэлзэж байв.
- Мэргэшлийн үндэсний тогтолцоо бий болгох ажил зогсонги байдалд орсон. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг мэргэжил, мэргэшлээр тоо, чанарын хувьд судлах, мэдээллээр хангах үйл ажиллагаа хангалттай биш, тогтмолжоогүй байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ОДОOGИЙН УЗЭЛ БАРИМТЛАЛ

/хөгжлийн бодлого нь хөдөлмөр эрхлэлт төвтэй бус/

Макро эдийн засгийн
бодлоготой уялдаагүй

Хөдөлмөр эрхлэлтийн
нийтлэг үйлчилгээ,
хөдөлмөр эрхлэлтийг
дэмжих арга хэмжээ
гэсэн 2 төрөлтэй

ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ УЙЛ
АЖИЛЛАГАА

ХҮН АМЫН
ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ
БОДЛОГЫН
ЧИГЛЭЛ

Хөдөлмөрийн
зах зээлийн
нийлүүлэлтийг
дэмжсэн

ҮР ДАГАВАР: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү ихэссээр байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН УЗЭЛ БАРИМТЛАЛ

/хөгжлийн бодлого нь хөдөлмөр эрхлэлт төвтэй/

Макро эдийн засгийн
бодлоготой уялдсан

Хөдөлмөр эрхлэлтийн
нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр
эрхлэлтийг дэмжих арга
хэмжээ, аж ахуй эрхлэлтийг
дэмжих арга хэмжээ гэсэн 3
төрөлтэй.

МАКРО
ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГО

ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН
БОДЛОГО

ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөрийн зах
зээлийн эрэлт,
нийлүүлэлтийг
дэмжсэн хөдөлмөр
эрхлэлтийн бодлого
хэрэгжүүлнэ

3

ҮР ДҮН: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү багасна.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

I. Хөдөлмөрэхлэлтийнүндэсний бодлогыг макроэдийн засаг, бус нутгийн хөгжлийн бодлого болон тодорхой салбарын бодлого, тухайлбал, жижиг, дунд үйлдвэр, малчид, хоршоодын хөгжлийг дэмжих, аж үйлдвэр, хөнгөн, хүнсний үйлдвэр, хөдөө аж ахуй, экспортын баримжаат үйлдвэрлэлийг хөгжүүлэх, боловсролын тогтолцоог зах зээлийн эрэлтэд нийцүүлэн шинэчлэх, асрахуй (Care), хэмнэхүй (Circular), хуваалцахуйн (Sharing), дижитал, нийгмийн болон эв санааны (Social and solidarity) эдийн засгийн үйл ажиллагааны бодлоготой нягт уялдуулан боловсруулж хэрэгжүүлдэг болох эрх зүй, санхүү, засаглал, институцын орчин бүрдүүлэх;

II. УИХ-ын дэргэд Эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн Зөвлөл байгуулж ажиллуулах;

III. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг ерөнхий чиг үүргийн статустай болгох;

IV. Дагах хуулиудын хүрээнд Төв Банк /Монголбанк/-ны тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Зөвшөөрлийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль зэрэг эдийн засгийн харилцааг зохицуулж байгаа хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;

V. Ажилгүй, ажил хайж буй иргэн ажилгүй гэж бүртгүүлсэн цагасаа эхлэн ажлын байртай болж, тогтвортой суурьшилтай ажилтан болтол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж үйлчлэх зохицуулалтыг тусгах буюу үйлчлүүлэгч төвтэй (Client centered), үр дүн, кейс менежментэд сууриссан, хүртээмжтэй, халамжаас хөдөлмөрт шилжихийг дэмжихүйц хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх;

VI. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн олон улсын төслүүдийн үр дүн, сайн туршлагыг бататган нутагшуулах үндсэн дээр уг үйлчилгээний нэр төрөл, хэлбэрийг олшруулах, цаашид тогтвортой хэрэгжүүлэх эрх зүйн орчныг хуульд тусгах;

VII. Хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний байгууллага (Job centers)-ын тогтолцоог бий болгох, эдгээр байгууллагын статус, ажилтнуудын талаар хуульд нарийвчлан зохицуулах, хөдөлмөрийн хувийн биржүүдтэй хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлэх, үүнтэй уялдуулан хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, хариуцлага, хяналтыг тодорхой болгох;

VIII. Аж ахуй эрхлэлтийг дэмжих зохицуулалтыг хуульд тусгай бүлэг болгон өргөжүүлэх, гарааны шинэлэг

бизнесийг дэмжих эко орчин бүрдүүлэх, эдийн засгийн хямрал, хүндрэл, гамшигийн нөхцөл байдал тулгарсан үед ажлын байр хадгалсан ажил олгогчийг дэмжих, тэтгэмж, санхүүгийн дэмжлэг, грант олгох олгох зэрэг идэвхтэй арга хэмжээг нэмж тусгах;

IX. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй болон идэвхтэй бодлогын уялдааг хангах зорилгоор ажилгүйдлийн даатгалаас хөдөлмөр эрхлэлтийн универсал даатгалд шилжих шинэчлэл хийх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын дийлэнхи хэсгийг энэхүү даатгалын сангаас бүрдүүлдэг болгох;

X. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан дотроо Инновацийн сан байгуулж, орон нутагт шинэлэг төсөл, хөтөлбөр туршин нэвтрүүлэхэд ашиглах;

XI. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхгүй ба идэвхтэй бодлогын арга хэмжээнд зарцуулах зарлагын ДНБ-д эзлэх хувийг тогтвортой нэмэгдүүлэх;

XII. Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлыг бодитой үнэлэхийн тулд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын болон орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

XIII. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн агентлаг нь хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн даатгалын асуудлыг хавсран эрхэлдэг, бие даасан бүтэц байх;


XIV. Үйлдвэрлэлийн ослын даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хувиар ажил олгогчийг дэмжих, ажилгүй болсон иргэн, тахир дутуу иргэдэд ажлын байртай болоход нь туслах дэмжлэг үзүүлэх.

Бодлогын голлох зөвлөмжүүдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн болон дагах хуулийн төсөлд тусгасан болно.

Түүнчлэн дээр дурдсан зөвлөмжүүдийг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2.1-д хөдөлмөр эрхлэлтийн үндэсний нэгдсэн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг шинэчилж, салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангах, 2.1.2.8-д олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшилийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилтуудыг дэвшүүлсэн байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ

/ИРГЭН, АЖИЛ ХАЙГЧ, АЖИЛ ОЛГОГЧИД САНАЛ БОЛГОЖ БУЙ ШИНЭЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД/



Тус танилцуулга мэдээллийг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав

2024 он



www.undp.org/mongolia , www.sdgbe-project.mn



+976-11-327585